



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Сүхбаатар сумын “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Аудитад хамрагдсан жил: 2023-2024

АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ

АУДИТ ХИЙГДСЭН ОБЪЕКТ: “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ

АУДИТЫН ТӨРӨЛ: ГҮЙЦЭТГЭЛИЙН

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 2024.06.07-2024.07.18

АУДИТАД ХАМРАГДСАН ХУГАЦАА: 2023-2024

Тайланг бэлтгэсэн:

**Дотоод аудитын нэгжийн
удирдлагын дарга**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
дэргэдэх Санхүүгийн хяналт,
дотоод аудитын албаны дарга,
СХШУАБ Т.Одсүрэн

Аудитыг гүйцэтгэсэн :

СХУБ,ахлах дотоод аудитор
Т.Мөнхзул

Огноо:2024 оны 07 дугаар
сарын 18 өдөр

Сүхбаатар сумын 2 дугаар баг.
Нутгийн удирдлагын II байр
sankhuu_audit_se@yahoo.com

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ,

2.1.Аудитын зорилго

2.2 Аудитын цар хүрээ

2.3.Аудитын арга аргачлал, хязгаарлалт

3.БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

3.1 Засаглалын талаар

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

3.3 Дотоод хяналтын талаар

4.АУДИТЫН ҮР ДҮН

4.1 Илэрсэн асуудлууд

5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10¹, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3² дахь хэсгийг үндэслэн аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2024 оны 06 дүгээр сарын 07-ны өдрийн 05 дугаар удирдамжийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын “Өргөн Сэлэнгэ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрлэлийн газрын (цаашид Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ-гэх) үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитыг Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийг тус тус үндэслэн санхүүгийн хяналт шалгалт, эрх зүйн нийцлийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ба 2023-2024 оны эхний хагас жилийн үйл явцыг хамруулан, дахин тооцоолох, тулган шалгах хяналтын горимыг ашиглах, холбогдох ажилтнуудтай ярилцах, дотоод хяналтын орчныг судлах, үнэлэх, ажил гүйлгээг батлах, хянах, бүртгэх, тайлагнах процессын эрсдэлийг үнэлэх, мөрдвөл зохих хууль тогтоомжийн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг бодитоор илэрхийлж тогтоох, зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдлыг шалгуур үзүүлэлтээр тодорхойлж ажиллав.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын удирдлага зохион байгуулалтын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;

Аудитаар тус газрын 2023 - 2024 оны эхний хагас жилийн үйл, ажиллагаа, төсөв, санхүү, өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалтыг хамруулна. Үүнд:

- ❖ *Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;*
- ❖ *Эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийн үр нөлөөг тооцох*
- ❖ *Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, холбогдох хууль тогтоомжууд,*

Засгийн газрын тогтоол шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

- ❖ *Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд бүрэн тусгасан эсэх.*
- ❖ *Улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалт, урсгал зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүн*
- ❖ *Гудамжны гэрэлтүүлгийн өртөг, нийтийн тээврийн зардлын тооцоолол үр нөлөөтэй байдал*
- ❖ *Журмын хашаа, нядалгааны газрын орлогын бүртгэл*
- ❖ *Худалдааны төв, “Сайханы хөтөл”-ийн түрээслэгч, хэрэглэгчийн хооронд байгуулсан гэрээний хэрэгжилт*
- ❖ *Махны бэлтгэлийн орлогын бүрдүүлэлт, өр авлагын тооцоо*
- ❖ *ААТҮГ-ын алдагдлыг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн*

Аудитын хамрах хүрээний хязгаарлалт:

“Өргөн Сэлэнгэ Үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023-2024 оны үйл ажиллагааны хамрах хүрээнд хязгаарлалт байхгүй болно.

2.3 Аудитын арга, аргачлал

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн албан тушаалтнаас асуулга тодруулга авах, нотлох зүйлсийг нягтлах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.

2.4 Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, журам, дүрэм, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Төсвийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Монгол Улсын Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн Түрээсийн гэрээ
- СТОУС, НББОУС болон бусад стандартууд

- “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дүрэм
- Бусад хууль, эрх зүйн актууд

2.5 Аудитын хугацаа, бүрэлдэхүүн

Дотоод аудитыг 2024 оны 06 дугаар сарын 10-ний өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны ахлах дотоод аудитор, СХШУБ Т.Мөнхзул гүйцэтгэв.

3. Байгууллагын сайн туршлага

Сайхны хөтлийг тохижуулан хувийн хэвшил аж ахуй нэгж байгууллагатай хамтран ажилласнаар Сүхбаатар орчмын байгалийн үзэсгэлэнт газрыг зорих дотоод гадаад жуулчдын тоо нэмэгдэж Сайхны хөтлөөс олох орлого 2021 онтой харьцуулахад 4.5 дахин нэмэгдсэн 2023 оны байдлаар 44.5 сая төгрөг болж өссөн бөгөөд 2024 оны хагас жилийн байдлаар 36.0 сая төгрөгийн орлого сайхан Сүхбаатар сумын үйлчилгээ үзүүлэх иргэдийн орлого нэмэгдсэн байна. Мөн Сайхны хөтлийн аялал жуулчлалаас үүсэн бий болсон хогийг ангилан ялгах чиглэлээр төслийн уралдаанд оролцож 20 сая төгрөгийн санхүүжилтийг эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр авсан байна.

Сум орон нутгийн удирдлагууд болон аж ахуй нэгж байгууллагуудтайгаа хамтран ажилласны үр дүнд 2021 оноос өмнө үүсэн бий болсон татварын өр алданги торгуулийн үлдэгдэл 269,2 сая төгрөгийг 2024 оны эхний хагас жилд 200 сая төгрөгөөр барагдуулж ажилласан байна.

Ажиллагсдын цалин хөлс цаг тухайдаа олгогдож ХХОАТ-ын болон нийгмийн даатгалын өргүй ажиллаж хэвшсэн.

3.1 Засаглалын талаар

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ИТХ-н 2022 оны 73 дугаар тогтоолоор “Өргөн Сэлэнгэ Үйлчилгээ” ОНӨААТҮГ нэртэйгээр үүсгэн байгуулагдсанаас өнөөдрийг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна.

“Өргөн Сэлэнгэ Үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын захирлаар 2022 оны 04 дугаар сарын 14-ний өдрөөс И.Чулуунболд томилогдон ажиллаж байна.

“Өргөн Сэлэнгэ Үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын эрхэм зорилго: Сүхбаатар сумын нийтийн аж ахуйн хэвийн үйл ажиллагааг явуулах, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх юм. Үүнд:

- Олон улсын худалдааны төв
- Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг
- Нийтийн тээвэр
- Мал нядалгаа
- Журмын хашаа
- Сайхны хөтөл зэрэг чиглэлд үйл ажиллагаа явуулж байна.

Олон улсын худалдааны төв, нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, нийтийн тээвэр, мал нядалгаа, журмын хашаа, Сайхны хөтөл, захиргаа санхүүгийн

алба гэсэн үндсэн хэсэгтэй 30 орчим ажилтан албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

Тус газар нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам боловсруулаагүй, эрсдэлийн бүртгэл хөтлөөгүй байна. Байгууллагын эрсдэлийн үйл явцыг үнэлэхэд хүлээн зөвшөөрөх эрсдэл, эрсдэлийн мэдээллийг ашиглах зэрэг үнэлэх шалгууруудын түвшин бүрд байгууллагын эрсдэлийн удирдлагыг тодорхойлж үнэлээгүй байна.

Удирдлагын “ёс зүйтэй байдлыг дэмжин урамшуулах байдал”, ёс зүйгүй үйлдлийн эсрэг хандах хандлага, авах арга хэмжээ буруу, удирдлага шаардлага тавьсан ч үе шатны хяналтыг дутуу орхигдуулснаас хэрэгжилт нь хангалтгүй. Нөгөө талаар албан хаагчид итгэл алдаж албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлоход эрсдэлийн соёл, эрсдэлийн засаглал, эрсдэлийн үйл явц эхлэлийн буюу 1-р түвшинд байна.

Иймд “Өргөн Сэлэнгэ Үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын захиралд байгууллагын эрсдэлийг тодорхойлж, төлөвлөгөө боловсруулан, биелэлтийг цаг тухай бүрд тайлагнан хариу арга хэмжээ авч ажиллахыг зөвлөж байна.

3.3 Дотоод хяналтын системийн талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг Зохион байгуулах нийтлэг журам”, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журамд дотоод хяналтын ажилтантай байна гэж тусгасан боловч дотоод хяналтын ажилтан томилон ажиллуулаагүй байна.

Иймд ААТҮГ-ын захиралд байгууллагын дотоод хяналтын сул орон тоонд ажилтан томилон ажиллуулах, эс бөгөөс дотоод нөөц бололцоондоо тулгуурлан бусдаар хавсран гүйцэтгүүлэхийг зөвлөж байна.

4. АУДИТЫН ҮР ДҮН

<u>Илэрсэн асуудал 1</u>	Эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй Аюул эрсдэлийг тодорхой хэмжээнд ярилцдаг боловч баримтжуулаагүй.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал:	Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөхдөө учирч болох эрсдэлүүдийг авч бүртгэж түүнийг бууруулах талаар ярилцдаг боловч баримтжуулаагүй, үнэлгээ хийгдээгүй байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт-2120

Асуудлын үндсэн шалтгаан:

Эрсдэлийн үнэлгээний ерөнхий ойлголт, ач холбогдол, үнэлгээ хийх арга аргачлалын талаар холбогдох албан тушаалтанд сургалт зохион байгуулдаггүй Эрсдэлийг зөвхөн шаардлагатай үед тодорхойлдог боловч бүрэн үнэлдэггүй.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

- Эрсдэлээ тодорхойлоогүй нөхцөлд байгууллага зорилгодоо хүрэхэд саад бэрхшээл тулгарах
- Байгууллагын үнэ цэн буурна, төсөв санхүүгийн хүндрэл учирч хэвийн үйл ажиллагаа алдагдана

Шийдвэр:

Байгууллагын албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгч, дотоод хяналтын нэгж хариуцсан ажиллагсдыг сургалтад үе шаттай хамруулж, чадавхжуулах
 -Гүйцэтгэх удирдлага нь байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн чиглэлээр ур чадвар бүхий ажилтан сонгон шалгаруулж авах
 -Байгууллагын эрсдэлийн түвшинг нэг шатлал ахиулан давтамжтай түвшинд шилжих зөвлөмж хүргүүлэх

<u>Илэрсэн асуудал 2</u>	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулаагүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал: Төсвийн төвлөрүүлэн захирагчид шууд харьяалагдах дотоод хяналт хариуцсан ажилтны орон тоог одоог хүртэл батлуулаагүй гүйцэтгэх чиг үүрэг тодорхойгүй, дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг боловсруулж батлуулаагүйгээс дотоод хяналт сул байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.4. дэх “Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.”	
Асуудлын үндсэн шалтгаан: Дотоод хяналт хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулаагүй, дотоод хяналтын чиглэлээр ажил зохион байгуулаагүй үндсэн үйл ажиллагаанд болон гүйцэтгэх удирдлагад тавих хяналтын тогтолцоог журамлаагүй, хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулах хяналтуудыг орхигдуулсан.	

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Удирдлагын хяналт, гүйцэтгэх удирдлагын уялдаа холбоо хангагдаагүй хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхой бусад нэгжийн дотоод хяналын үр нөлөө сул үнэлгээ дүгнэлт хангалтгүй байна.

Шийдвэр:

Өөрийн эрхлэх хүрээний асуудал хариуцсан байгууллагууд болон гүйцэтгэх удирдлага, болон үндсэн үйл ажиллагаанд хийх дотоод хяналт шалгалтын журмыг нэн яаралтай боловсруулах, дотоод хяналт хариуцсан ажилтантай болгож албан тушаалын тодорхойлолтод холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын заалтаар тусгаж өгөх. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.4. дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэх

<u>Илэрсэн асуудал 3</u>	ОУХТөвийн талбайн түрээсийн үнэ, тарифыг зах зээлийн нөхцөлд тохируулан оновчтой тогтоогоогүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө ихтэй
<p>Бодит байдал: Худалдааны төвийн худалдааны лангуу талбайн түрээсийн орлого сүүлийн 3 жилийн дунджаар 442,6 сая төгрөг гэтэл үйл ажиллагааны зарцуулж байгаа 11 албан хаагчийн жилийн цалин 215.2 сая төгрөг байр ашиглалттай холбоотой тогтмол дулаан,ус, цахилгааны зардал 124.5 сая гэрэлтүүлэг болон бие засах газрын болон бусад урсгал зардалд дунджаар 50.0 барилгын элэгдэл 62.5 сая төгрөг нийт дүнгээр 452.2 сая төгрөг болж байгаа нь ашиггүй ажиллах эрсдэлийг бий болгож байна.</p> <p>2016 онд ОУХТ байгуулагдсанаас хойш түрээсийн үнэ тариф /1мкв өвлийн улиралд буюу 6 сараар 23750 төгрөгөөр зуны улиралд 12750 төгрөгөөр тогтоож байгаад 2023 онд зуны 16750 төгрөг өвлийн улирлын тарифыг өөрчлөөгүй байна. Энэ нь үнийн өсөлттэй холбоотойгоор байгууллагын урсгал зардал жил бүр нэмэгдэж байгаагаас алдагдалтай ажиллах өөр өөрийгөө санхүүжүүлж чадахгүй байх эрсдэл үүссэн. Түрээсийн орлого нэмэгдэхгүй, харин урсгал зардал өссөөр байгаа нь байгууллага өөрийгөө санхүүжүүлэх чадамжаа алдаж, үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэхэд хүндрэл учирч байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <p>Сүхбаатар сумын ИТХ-ын 2022 оны 38 дугаар тогтоолоор баталсан Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3 дах “Худалдааны төвд үйл ажиллагаа явуулах иргэн, байгууллагатай гэрээ хийх байр, талбай ашиглуулах, ашиглалтын төлбөр тооцоог хийх” 8 дугаар зүйлийн 8.1.5 дах “Инфляц, зах зээлийн үнэ ханштай уялдуулан үйлчилгээний үнийн саналаа эрх бүхий, албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлж мөрдөх”,</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан:</p>	

Инфляц, эрчим хүчний үнэ, дулаан, цахилгаан, цалин хөлс, засвар үйлчилгээ зэрэг томоохон зардлууд жил бүр нэмэгдэж байхад түрээсийн зардлын тариф сүүлийн 8 жилд сард зуны улиралд 1/мкв нь 4000 мянган төгрөгөөр нэмэгдэж бараг өөрчлөгдөөгүй байна

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Тариф хямд, оновчгүй байснаар талбайг үр ашигтайгаар ашиглахад сөргөөр нөлөөлж, санхүүгийн үр өгөөжийг бууруулна . Мөн байгууллага боломжит орлогоо бүрэн олж чадахгүй байна. Энэ нь байгууллагын санхүүгийн эх үүсвэрийг багасгаж, тогтвортой үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө.

Шийдвэр:

ОУХТөвийн талбайн түрээсийн үнэ, тарифыг зах зээлийн нөхцөлд тохируулан оновчтой тогтоох **зөвлөмж** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Илэрсэн асуудал 4	2021 онд улсын комисст хүлээлгэн өгсөн Сайханы хөтлийн цогцолборыг хөрөнгийн орлогод бүртгээгүй зөрчил илэрлээ.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал:	Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2021 онд улсын комисст хүлээлгэн өгсөн 759,924.9 мянган төгрөгийн өртөг бүхий Сайханы хөтлийн цогцолборыг санхүүгийн бүртгэлд (хөрөнгөд) бүртгээгүй байна. Энэ нь улсын хөрөнгийг бүртгэлд хамруулаагүй, санхүүгийн удирдлага болон нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт муу байгааг харуулж байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “үнэн зөв байх”, 5.1.5 дах “хэмжигдэхүйц байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дах “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, ...” Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаал "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-н 11.1.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Тухайн хөрөнгийг байгууллагын хөрөнгөд бүртгэж аваагүй байна. Хөрөнгө хүлээлгэн өгөх, бүртгэлд тусгах үе шат бүрд тавих хяналт, хариуцлагын тогтолцоо дутагдалтай байна
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Бүртгэлгүй хөрөнгө нь ашиглалтгүй үлдэх, хариуцлага хүлээх эзэнгүй болох, мөн буруу ашиглагдах нөхцөлийг бүрдүүлнэ. Байгууллагын санхүүгийн байдлыг үнэн зөв үнэлэх боломжгүй болно
Шийдвэр:	

Цаашид Сайханы хөтлийн цогцолборыг хөрөнгийн орлогод бүртгэх **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Илэрсэн асуудал 5	Сайхны хөтлийн цогцолборт байрлаж байгаа нийтийн ариун цэврийн барилгыг зориулалт бусаар ашиглаж байна
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: онд ашиглалтад орсон нийтийн ариун цэврийн барилгыг зориулалтын бусаар ашиглаж, цайны газар болгон ажиллуулж байна. Энэ нь барилгын анхны ашиглалтын зориулалт болон холбогдох дүрэм, журмыг зөрчиж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлд сөргөөр нөлөөлж байна. Барилгын ашиглалтын зориулалтыг дур мэдэн өөрчилсөн нь Барилгын тухай хууль болон холбогдох стандартын зөрчиж байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Монгол Улсын Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дах. “барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцийг арчлан хамгаалах, зориулалтыг өөрчлөхгүй байх”, Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. дэх “Хот, суурин газрын төлөвлөлт, барилга байгууламж нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн, эрүүл ахуйн нөхцөл, барилгын норм, нормативын шаардлагыг хангасан байна”	
Асуудлын үндсэн шалтгаан: Нийтийн ариун цэврийн барилгыг зориулалтын бусаар ашиглаж, цайны газар болгон ажиллуулсан байна	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Эрүүл ахуйн стандартыг хангахгүй байх, хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө. Үйлчлүүлэгчдийн эрүүл мэндэд эрсдэл учирч, хордлого болон бусад халдварт өвчин гарах магадлалтай. Нийтийн ариун цэврийн байгууламжийн хүрэлцээ, хүртээмж муудаж, иргэдийн тав тух, амьдралын чанарт сөргөөр нөлөөлнө.	
Шийдвэр: Цаашид нийтийн ариун цэврийн барилгыг зориулалтын дагуу ашиглах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.	

Илэрсэн асуудал 6	Сайханы хөтлийн цогцолбор газрыг үзэх иргэдэд олгох тасалбарыг э-баримтаар баталгаажуулаагүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: Байгалийн үзэсгэлэнт цогцолбор газрыг үзэх иргэдэд тасалбарыг баримтжуулах, дугаарлах үйл ажиллагаа хангалтгүй байна. Тасалбар олголт, орлогын бүртгэл	

зохих ёсоор хийгдээгүйгээс санхүүгийн тайлангийн орлого тодорхойгүй болж, орлого нуух, алдагдуулах эрсдэл үүснэ.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ", 28 дугаар зүйлийн 28.5 дахь "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм..."

Асуудлын үндсэн шалтгаан:

Сайханы хөтлийн цогцолбор газрыг үзэх иргэдэд, борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх ажлыг зохион байгуулаагүй

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Тасалбар борлуулалтын цахим систем ашигладаггүйгээс тасалбар борлуулалтын орлогын бүртгэл үнэн зөв эсэхэд хяналт тавих боломжгүй.

Шийдвэр:

Цаашид Сайханы хөтлийн цогцолбор газрыг үзэх иргэдэд, борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх ажлыг зохион байгуулах **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв

<u>Илэрсэн асуудал 7</u>	Байгууллагын бүтэц орон тоог ажлын байрны чиг үүрэгтэй уялдуулан шинэчлэн батлуулаагүй.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө дунд
Бодит байдал:	<p>"Өргөн сэлэнгэ" ОНӨААТҮГ нь Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2022 оны 73 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон өөрчлөгдсөн боловч байгууллагын орон тооны дээд хязгаарыг сумын Засаг даргаар батлуулаагүй байна.</p> <p>Байгууллагын бүтэц, орон тоог ажлын байрны чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэн батлуулаагүй байна. Үүнээс шалтгаалан зарим албан тушаалын чиг үүрэг давхцах, тодорхойгүй байх, хүний нөөцийн төлөвлөлт, удирдлагын зохион байгуулалт хангалтгүй байгаа нь ажлын үр бүтээмжид сөргөөр нөлөөлж байна.</p>

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Сүхбаатар сумын ИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 38 дугаар тогтоолоор баталсан Өргөн Сэлэнгэ ОНӨААТҮГ-ын дүрмийн 2 дугаар зүйл 2.1 дэх “Үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сүхбаатар сумын ИТХ, төлөөлөн хэрэгжүүлэгч нь сумын засаг дарга байна”.

Асуудлын үндсэн шалтгаан:

Байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, ажил үүрэгт тохирсон бүтэц, орон тооны төлөвлөлт хийгдээгүй, орон тооны дээд хязгаарыг сумын Засаг даргаар батлуулаагүйгээс голлон шалтгаалсан.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Бүтэц орон тоог ажлын байрны чиг үүрэгтэй уялдуулан шинэчлэн батлуулаагүйн улмаас үр ашиггүй орон тоонд цалингийн зардал төлөвлөснөөр санхүүгийн хувьд үр ашиггүй байх үндэс болно.

Шийдвэр:

“Өргөн Сэлэнгэ” ОНӨААТҮГ -ын ажлын байрны чиг үүргийн нягтруулж бүтцийг оновчтой болгох замаар бүтэц, орон тооны дээд хязгаарыг сумын Засаг даргаар шинэчлэн батлуулж ажиллах **зөвлөмж** хүргүүлэхээр шийдвэрлэв.

<u>Илэрсэн асуудал 8</u>	Худалдан авах ажиллагааны босго үнийг баримтлаагүй, шууд худалдан авалт хийсэн байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал:	ОНӨААТҮГ нь худалдан авах ажиллагааны босго үнэнээс давсан дараах зардлуудад шууд худалдан авалт хийсэн байна.
Гэрэлтүүлгийн гэрэл:	Төсөвт тусгасан дүн: 34,200.0 мянган төгрөг. Худалдан авалтын ажиллагааг цахимаар болон нийтэд нээлттэй зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалгүйгээр худалдан авалт хийсэн. Эдгээр худалдан авалтыг холбогдох хууль, журмын дагуу нээлттэй зарлаж, үнийн санал авч гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Төсвийн тухай хуулийн 24.4 “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.”, ТБОНӨХБАҮХАТ Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1. дэх “Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна.”, 31.1.2. дэх “харьцуулалт;”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа -20 сая төгрөг, ажил -20 сая төгрөг”
Асуудлын үндсэн шалтгаан:	Худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулаагүй. Худалдан авах үйл явцад дотоод хяналт, шалгалт хангалтгүй байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулаагүйгээс үнийн зөрүүтэй худалдан авалт хийх, санхүүгийн үр ашиггүй зардал гарах эрсдэлтэй

Шийдвэр:

Цаашид худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид заасан тендер шалгаруулалтын аргыг сонгохдоо босго үнийг баримталж ажиллуулах, дахин давтан гаргахгүй байх **зөвлөмж** хүргүүлэхээр шийдвэрлэв.

<u>Илэрсэн асуудал 9</u>	Ашиглах боломжгүй болсон, элэгдлээ бүрэн нөхсөн нийт 170,325.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган сумын ИТХ, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө бага
Бодит байдал: Газар дээр нь очиж тулган баталгаажуулахад 2024 оны хагас жилийн тайлангаар ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн 170,325.1 мянган төгрөгийн 12 төрлийн үндсэн хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж бүртгээгүй байна. Үүнээс 40,955.1 мянган төгрөгийн хөрөнгө хэвийн ашиглагдаж, 129,120.0 мянган төгрөгийн хөрөнгө эвдэрсэн, 250.0 мянган төгрөгийн хөрөнгө ашиглагдахгүй болсон байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9.1 дэх “Аймаг, нийслэлд төрийн өмчийн төлөөлөгч ажиллана.”	
Асуудлын үндсэн шалтгаан: Үндсэн хөрөнгийн тооллогыг зохих журмын дагуу хийж гүйцэтгээгүйн улмаас ашиглах боломжгүй хөрөнгүүдийн тооцоо судалгааг гаргаж орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Дээрх хөрөнгө нь байгууллагын үндсэн хөрөнгийн дансны дүнг нэмэгдүүлж, бодит үнэ цэнийг бууруулж байна.	
Шийдвэр:	

Цаашид үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглах боломжгүй, эдийн засгийн хувьд үр өгөөжгүй хөрөнгийн тооцоо судалгааг гарган, орон нутгийн өмчийн газарт актлуулах саналыг хүргүүлэх **зөвлөмж** өгөв.

5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дотоод аудитын хорооны даргын батлагдсан удирдамжаар Өргөн Сэлэнгэ ОНӨААТҮГ-ын 2023-2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын хүрээнд байгууллагын засаглал, санхүүгийн үйл ажиллагаанд хууль, тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлдэггүй. Санхүүгийн сахилга бат муу, 2021 онд улсын комисст хүлээлгэн өгсөн 759,924.9 мянган төгрөгийн өртөг бүхий Сайханы хөтлийн цогцолборыг орлогод бүртгээгүй, ОХУТөвийн түрээсийн орлогыг зах зээлийн үнэ тарифтай уялдуулаагүй, он дамнасан өр төлбөрийг барагдуулах тал дээр бодитой ажил, арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулдаггүй зэрэг алдаа зөрчлийг үндэслэн **“Хангалтгүй”** гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Хангалтгүй	Засаглал эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “эхлэлийн буюу 1-р түвшин”-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 87.5%-иас дээш нь “нөлөө ихтэй” гэж үзсэн.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
АХЛАХ ДОТООД АУДИТОР



Т.МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН:

“ӨРГӨН СЭЛЭНГЭ” ОНӨААТҮГ-ЫН

ЗАХИРАЛ

НЯГТЛАН БОДОГЧ:



И.ЧУЛУУНБОЛД

Т.БАЯРЦЭЦЭГ